



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар

1/85

Улаанбаатар хот

Багануур дүүргийн Цагдаагийн
хэлтсийн данс бүртгэлд хөрөнгө
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилчин албан хаагчдаас хандивласан нийт 2,850,000.0 (хоёр сая найман зуун тавин мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500662

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны
 дугаар сарын 1-ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэр-лэсэн он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр
1	Сүүдрэвч /Төв байрны/	Банз	модон	2022	Сайн	ш	2	1,000,000	2,000,000	Замын цагдаагийн тасаг	Хандив
Барилга, байгууламж орон сууц											
2	Шкаф /гал тогоо амралтын байр/	шахмал хавтан	хүрэн модон	2022	сайн	ш	1	150,000	150,000	Эрүүгийн тасаг	Хандив
Тавилга, эд хогшлын дүн											
3	Ус цэвэршүүлэгч /3 давхар/	Magis	1	2022	сайн	ш	1	700,000	700,000	Захиргааны удирдлагын тасаг	Хандив
Машин тоног төхөөрөмж											
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								700,000.0	2,850,000.0		

